


ЦЮ ЦЮОСЫ "ДУНД ГУРВАН ХИЛИЙН МОНГОЛ ВАН ТАЙЖ НАРЫН НАМТАР" НОМЫН ТУХАЙ

"Дунд гурван хилийн монгол ван тайж нарын намтар" (Вань Лигийн цэргийн гавьяаны тэмдэглэлийн 7,8,9-р бүлгүүд) хэмээх эл номыг 2011 онд Улаанбаатар хотын "Соёмбо принтинг" хэвлэлийн газар хэвлэжээ. Уг номыг Монгол Улсын нэрт түүхч, шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, доктор Л.Жамсран орчуулж, түүний үр хүүхдүүд эрхлэн хэвлүүлсэн байна.

Түүхч, доктор Л.Жамсран 1953 онд МУИС-ийн Түүхийн ангийг төгсгөөд Багшийн дээд сургууль, МУИС-ийн Түүхийн тэнхимийн эрхлэгч, багшаар ажиллаж байгаад 1957-1962 онд Хятадын Бээжин Их сургуулийн аспирантурт сурч, түүхийн шинжлэх ухаанаар эрдмийн зэрэг горилж, сурвалж судлалын чиглэлээр судалгаа хийжээ. Хятадын Мин улсын түүхч Цю Цюосигийн бичсэн "Вань Лигийн цэргийн гавьяаны тэмдэглэл" хэмээх номоос Монголын түүхтэй холбоотой бүлгүүд, XIV-XVI зууны Монголын түүхийг судлахад үнэ цэнэтэй сурвалж хэрэглэгдэхүүн болохын хувьд уг зохиолоос Монголын ноёдын түүх намтарт холбогдох хэсгийг түүвэрлэн авч орчуулаад, удиртгал, хавсралт бичсэн байна. Эл бүтээл нь Монголын түүхийн багахан судлагдсан үед холбогдох хятадын эх сурвалж болох аж.

Цю Цюоси тэмдэглэлийнхээ 7,8,9 дүгээр бүлгийг "Дундгурван хязгаар" гэж гарчиглаад Сюань Фу, Датун, Шаньси зэрэг гурван




хязгаарын гаднах Монголын ван тайж бүгд нийлсэн 24 хүний намтрыг бичсэн байсныг 1960-аад онд аспирантурт суралцаж байсан Л.Жамсран орчуулан судалж шинжилж эрдмийн зэрэг хамгаалж байжээ.

Хятадын түүхчийн энэхүү бүтээл одоо хэр нь монгол хэлээр гараагүй бөгөөд монголын түүхэнд холбогдох мэдээ сэлт ихээхэн агуулсан эх сурвалж хэрэглэгдэхүүн болохын хувьд тун ач холбогдолтой юм. Уг бүтээлийг хятад төвийн үүднээс бичсэн, монголчуудыг дайсан мэтээр үзэж, дорд үзэж басамжилсан зүйл байгаа хэдүй ч монголчууд тооны хувьд цөөн ч угаас зоримог дайнч үйлдлээрээ өөрсдийн үзэл бодол, санаагаа тулган хүлээлгэж байсныг тодоор тусгажээ. Зохиолд

өгүүлэн буй үеийн түүхэн үйл явдлын он цаг, түүхэн газарзүйн талаархи тодорхой мэдээлэл нь түүхч судлаачдад чухал хэрэглэгдэхүүн болно.

Эртний ханз үсгээр бичигдсэн энэ бүтээл ер хэвлэгдээгүй байсан агаад харин хятад



Хятадын түүхч судлаачид энэ бүтээл нь 1980-аад онд Хятадын улсын түүхч судлаачид олдсон гэдгийг мэдэгдсэн байна. Энэ бүтээл нь 1980-аад онд Хятадын улсын түүхч судлаачид олдсон гэдгийг мэдэгдсэн байна. Энэ бүтээл нь 1980-аад онд Хятадын улсын түүхч судлаачид олдсон гэдгийг мэдэгдсэн байна.

эх бичгийг Өвөр Монголын Их сургууль "Мин улсын үеийн Монголын түүхийн хятад сурвалж бичгийн эмхтгэл"-д оруулж, 2007 онд хятад хэлээр Хөх хотноо хэвлүүлсэн ажээ.

Энэ бүтээл нь 1980-аад онд Хятадын улсын түүхч судлаачид олдсон гэдгийг мэдэгдсэн байна. Энэ бүтээл нь 1980-аад онд Хятадын улсын түүхч судлаачид олдсон гэдгийг мэдэгдсэн байна. Энэ бүтээл нь 1980-аад онд Хятадын улсын түүхч судлаачид олдсон гэдгийг мэдэгдсэн байна.